


## Цэвэршүүлэх үйлдвэрийн хөргөлтийн цамхагт дэлбэрэлт болж, гал гарсан



1-р зураг. Хөргөлтийн цамхагт гал гарсан

2013 оны 8 сард Энэтхэг дэх цэвэршүүлэх үйлдвэр хөргөлтийн цамхгийн шинэ үүр ашиглалтад оруулах туршилтад хийсэн. Шинэ үүр рүү эргэлтийн ус оруулж эхлэх үед их хэмжээний хөнгөн нүүрс-устөрөгчийн хий, шингэн алдагдсан. Улмаар тухайн орчинд өндөр хэмийн ажил хийж байснаас болж гал авалцан шатсан. Нийт 29 хүн нас барж, олон хүн түлэгдэж гэмтсэн.

Ослын судалгаагаар дулаан солилцуураар алдагдсан шатамхай нүүрс-устөрөгч хөргөлтийн цамхгийн усны шугам хоолойн өндөр цэгт хуримтлагдсан байна гэж дүгнэсэн. Шугам хоолойн хэсэгт хөдөлгөөнгүй хуримтлагдаж байгаад хөргөлтийн цамхгийг ашиглалтад оруулах туршилтын үед А хаалтыг (2-р зураг) нээх үед хөдөлгөөнд орсон. Дулаан солилцуураас алдагдсан шатамхай шингэн хөргөлтийн цамхагт орсон. Хөргөлтийн цамхаг дотор болон эргэн тойронд нь их хэмжээний хийн үүл үүсэж, гал авалцсан. Нас барсан, түлэгдэж гэмтсэн хүмүүсийн ихэнх нь тухайн хэсэгт ажиллаж байсан гэрээт ажилчид байсан. Тухайн компанийн шинэ тоноглол ашиглалтад оруулах үед бусад ажлыг зогсоох журам хэрэгжээгүй.



2-р зураг. Хөргөлтийн цамхгийн схем зураг

Ашигласан материал: OISD Newsletter Vol. 2 Issue 9

### Та мэдэх үү?

- Ихэнх нүүрс-устөрөгч уснаас хөнгөн тул шугам хоолойн өндөр цэгт хуримтлагддаг.
- Тогоо ба хоолой хэлбэрийн дулаан солилцуурын хоолой нь энгийн шугам хоолойноос нимгэн ханатай. Багахан зэврэхэд л муудаж цоордог.
- Дулаан солилцуурын хоолой нь тогоон дотор байрлах тул шалгахад хэцүү.
- Тоноглолыг асаах, ашиглалтад оруулах үед аюулгүйн зарим систем ажиллахгүй, эсвэл байхгүй, мөн тухайн хэсэгт олон хүн байх магадлалтай тул аюултай нөхцөл үүснэ.
- Хөргөлтийн цамхгийн дотоод хийцийг мод, шилэн мяндас зэргээр хийсэн байдаг. Гал гарсан үед унтраахад хэцүү.
- Хөргөлтийн цамхагт хөргөлтийн ус л байх тул аюул багатай гэж үзэх нь түгээмэл.
- Хөргөлтийн цамхгийг хий ялгаж гадагшлуулах хоолой, хий илрүүлэгч, бороожуулах гал унтраагуураар тоноглож иймэрхүү аюулыг багасгаж болно.

### Та яах ёстой вэ?

- Үйлдвэрлэлийн материал хөргөлтийн шингэнийг бохирдуулж болзошгүй. Хөргөлтийн шингэний системд зөвхөн ус л байх ёстой гэж найдаж болохгүй.
- Хөргөлтийн усны шугам хоолойн урсгалыг нээх, хаах үед шугам хоолой дотор юу байх, юу алдагдах боломжтойг бодолцож үз.
- Тоноглолыг асаах үед аюултай материал алдагдаж болзошгүй. Ойр орчимд буй ажилчдад нөхцөл байдлыг хэлж, ажлаа зогсоож, талбайг орхиж гарах, ажлаа эхлэхэд аюулгүй гэдгийг мэдэгдэх хүртэл буцаж орохгүй байхыг сануулах.

Үйлдвэрлэлийн материалаар бохирдсон тохиолдолд хөргөлтийн ус ч аюултай материал болж хувирдаг.